# ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
УЛСЫН БҮРТГЭГЧ Ө.ГАНЗОРИГ

ХЯНАСАН:
ОРХОН АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ОТГОНБАЯР

2025 он

# ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2022 онд “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 стандартыг хэлтэстээ хэрэгжүүлэн, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Бидний нэвтрүүлсэн энэхүү стандарт нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд Франц улсын “Afnor” группээр аудитлагдсан олон улсын гэрчилгээ юм.

**АЛСЫН ХАРАА**

- Дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ
- Дэлхийн түвшинтэй хөл нийлүүлнэ

**ЭРХЭМ ЗОРИЛГО**

- Төрийн бүртгэлийг төгөлдөршүүлж
- Улсын бүртгэлийг ухаалагжуулж
- Цаасан бүртгэлийг цахимжуулж
- Иргэдэд ээлтэй байгууллага байна

**УРИА**

- Эхээс мэндэлж нэрээ авахаас
- Эх дэлхийдээ шингэн үдүүлэх
- Удам орон зүйд бид үйлчлэнэ
- Улсын бүртгэл тантай хамт

**ЧАНАРЫН БОДЛОГО**

- Хууль тогтоомжийг чухалчилж
- Хүний эрхийг дээдэлж
- Үйл ажиллагаагаа сайжруулж
- Үйлдэл бүхнээ хянаж
- Чадвар ёс зүйгээр манлайлж
- Чадамж гүйцэтгэлээр тэргүүлж
- Түмэн хэрэглэгчийг хамруулсан
- Төрийн санах ой байна.



KZ.Q.00.0579

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар: MC 61/QMS 158 22

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, 61025, Оюут баг, Захиргааны 2-р байр, 1-р давхар

үйл ажиллагаандаа менежментийн тогтолцоог

ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 9001:2015

стандартын шаардлагын дагуу нэвтрүүлснийг баталгаажуулан гэрчилгээ олгов.

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Улсын бүртгэлийн үйлчилгээ

Анх олгосон огноо: 2022.07.07

Олгосон огноо: 2022.07.07
Хүчинтэй хугацаа: 2025.07.06

МОНСЕРТФ ХХК
Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, 7-р хороолол, Алтайн гудамж 281,
Хоймор оффис, 15 давхар, 1505 тоот
Утас: 70115522, E-mail: info@moncertf.mn



## ТӨРИЙН БАЙГУУЛАГЫН АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН УЛСЫН ҮЗЛЭГ

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2025 оны “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоолын хүрээнд зохион байгуулагдсан. Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын урьдчилсан үзлэг тус хэлтэс хамрагдсан.










## НЭГ. ХҮНИЙ НӨӨЦ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 09 сарын 01-ны өдрийн А/157 дугаар тушаалын дагуу Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2025 онд төрийн захиргааны 18, төрийн үйлчилгээний мэргэжлийн 5, төрийн үйлчилгээний 1, үндсэн гэрээт 1, түр гэрээт 4 нийт 29 албан хаагчтайгаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан бүтэц, орон тоогоор ажиллалаа..




Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаандаа “Байгууллагын үйлчилгээний стандарт”-ыг мөрдөн ажиллаж байна.



## ХОЁР. СУРГАЛТ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2025 оны 11 сарын 07-ны байдлаар хэлтсийн сургалтын төлөвлөгөөний дагуу дотооддоо 16 удаагийн сургалт зохион байгуулж, Төрийн албаны зөвлөл, Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймаг орон нутгаас зохион байгуулсан 29 сургалт, нийт 45 сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулсан.

| Д/д | Зохион байгуулагдсан сургалтын хамрах хүрээ | Сургалтын тоо |
|---|---|---|
| 1 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой | 7 |
| 2 | Иргэний улсын бүртгэлтэй холбоотой | 7 |
| 3 | Архивч, бичиг хэрэг, нягтлантай холбоотой | 5 |
| 4 | Мэдээлэл технологийн чиглэлээр | 4 |
| 5 | Монгол бичгийн сургалт | 5 |
| 6 | Хүний нөөцийн системийн сургалт | 1 |
| 7 | Дотооддоо зохион байгуулсан | 16 |

| | |
|---|---|
| **Нийт** | **45** |

**Дотоодод зохион байгуулсан сургалтын тухай:**

| Д/д | Сургалтын агуулга | Зураг |
|---|---|---|
| **1** | “Хөрөнгө орлогын мэдүүлэг хэрхэн гаргах, анхаарах асуудал” улсын бүртгэгч Ө.Ганзориг /2025.01.21/ |  |
| 2 | “Иргэний улсын бүртгэлийн сангаас иргэн, Хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл олгох тухай” улсын бүртгэгч Б.Шинэбаяр, Д.Болорцэцэг /2025.01.28/ |  |
| 3 | “Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт” улсын ахлах бүртгэгч Л.Үзмээ, архивч Б.Энхтуул /2025.02.11/ |  |
| 4 | “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” /2024-2030 он / улсын бүртгэгч О. Сарангэрэл /2025.03.04/ |  |
| 5 | “Байгууллагын соёл, үйлчилгээний стандарт” улсын бүртгэгч Д.Баярмаа /2025.03.18/ |  |

| | | |
|---|---|---|
| 6 | “Гэрлэсний – иуб15, Гэрлэсний бүртгэл дуусгавар болсны бүртгэл- иуб16, Нас барсны бүртгэл –иуб18” улсын бүртгэгч Н.Түвшинжаргал /2025.03.25/ |  |
| 7 | “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцлийг хангах талаар төрөөс баримталж буй бодлого” улсын бүртгэгч Ж.Даваадорж /2025.04.01/ |  |
| 8 | “Гадаад паспортын бүртгэл, Гадаад паспорт олголтын бүртгэл” улсын бүртгэгч Ц.Оюунсүрэн /2025.04.22/ |  |
| 9 | Хэлтсийн Авлигын эсрэг үйл ажиллагааны дэд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор УБЕГ-аас зохион байгуулсан сургалтад улсын ахлах бүртгэгч О.Үзмээ, улсын бүртгэгч Ц.Оюунсүрэн, Д.Болорцэцэг нар хамрагдсан бөгөөд 2025.04.28-ны өдөр албан хаагчдад танилцууллаа. |  |
| 10 | “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” улсын ахлах бүртгэгч С.Жамбалсүрэн /2025.05.27/ |  |

➢ Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, ёс зүй сахилга хариуцлагыг чанаржуулах зорилгоор “Бүсчилсэн хөгжил - Төрийн албаны манлайлал” хойд бүсийн төрийн албан хаагчдын сургалт, зөвлөгөөн хэлэлцүүлэгт холбогдох албан хаагчдыг хамруууллаа.





➢ Хэлтсийн дэргэдэх Эцэг эхийн зөвлөлийн санаачлагаар Орхон аймгийн хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын газрын мэргэжилтэн Ц.Уянгатай хамтран ‘’Гэр бүлийн үнэ цэнэ, хүүхэд хүмүүжлийн эерэг арга’’ сэдэвт сургалт зохион байгуулсан.




➢ Мөн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ойлголт, хамаарах асуудал” сэдвээр албан хаагчдад мэдээлэл өгөхөөр Орхон аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын ХАБАЭ-н хариуцсан мэргэжилтэн Ө.Есүхэйтэй хамтран сургалт зохион байгуулсан.



➢ Орхон аймгийн Засаг даргын Тамгын газраас Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам шинэчлэгдсэн батлагдсантай холбогдуулан зохион байгуулсан сургалтад Хяналтын улсын байцаагч Б.Шинэбаяр, улсын бүртгэгч Ө.Ганзориг нар хамрагдлаа.




➢ Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 2025 оны 03 сард зохион байгуулагдсан “Удирдах ажилтны сургалт”-д хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч нар оролцож, сургалтын талаарх мэдээллийг албан хаагчдад танилцууллаа.



➢ Улсын бүртгэлийн байгууллагын Мэдээллийн технологийн албан хаагчдын нэгдсэн сургалт 2025 оны 04 сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд хэлтсийн Мэдээлэл технологийн ажилтан Б.Лхамцэрэн хамрагдаж, сургалтаар сурч мэдсэн хиймэл оюун ухаан, сүлжээний аюулгүй байдал, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн хамгааллын чиглэлээр болон төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага зэрэг сэдвүүдээр албан хаагч нарт мэдээлэл, сургалт хийлээ.





➢ Архивын хадгалах хугацаа нь дуусан баримтыг Жаргалант сумын уурын зууханд устгалд оруулав.





➢ Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх” журамд заасны дагуу Онцгой байдлын газрын заавар зөвлөмжийн дагуу гамшгаас хамгаалах дадлага, сургуулилтад хамрагдсан.






- "Хотын их цэвэрлэгээ" аяны хүрээнд 2025 оны 04 сарын 04-ны өдөр хуваарьт талбайн хог хаягдлын цэвэрлэгээ хийх ажлыг зохион байгууллаа.





- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөр, “Бүх нийтээр мод тарих өдөр”-т нэгдэн 2025 оны 05 сарын 09-ны өдөр 132 ширхэг шар хуайс, 2025 оны 10 дугаар сарын 02 ны өдөр 73 ширхэг нийт 205 ширхэг мод, суулгац тарьсан.




- Төрийн албаны хүний нөөцийн бүрдлийг хангах 2025 оны I болон II, III дугаар улирлын Төрийн албаны ерөнхий шалгалтуудад оролцогчдыг хурууны хээ /биеийн давхцахгүй өгөгдөл/-ээр таниулан бүртгэн ажилласан.






- “Нээлттэй засаглалын түншлэлийн долоо хоног” 2025 оны 05 сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан өдөрлөгт тус хэлтэс иргэдэд тоон гарын үсэг олгох, гадаад паспортын захиалга авах үйлчилгээг газар дээр нь үзүүлж, зөвлөгөө мэдээ мэдээллийг өгч ажилласан.






➢ 2025.03.26-ны өдөр иргэний гаргасан хүсэлтийн дагуу, ирэх боломжгүй эрүүл мэндийн шалтгаантай иргэнд зөөврийн тоног төхөөрөмж ашиглан гэрт нь очиж, гэрлэсний бүртгэлийг хийлээ.




➢ Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойн арга хэмжээний хүрээнд, ажилтан албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх “Спорт-2025" нэгдсэн тэмцээнд ХАНГАЙН БҮСИЙН тамирчид идэвхтэй оролцож "САГСАН БӨМБӨГ"-ийн эрэгтэй төрөлд ГУТГААР байр эзэлж ХҮРЭЛ МЕДАЛЬ хүртсэн.





➢ “Үндэсний бичиг үсгийн баяр-2025” тохиолдуулан жил бүр уламжлал болгон зохион явуулдаг Монгол бичгийн “Алтан хонх” тэмцээнд 16 байгууллагын 44 албан хаагчид мэдлэг чадвараа сорин оролцсоноос тус хэлтсийн Иргэний бүртгэлийн архивч Б.Энхтуул тусгай байрт шалгарлаа.




Үндэсний их баярын наадмын хүрээнд “Дээлтэй Монгол-2025” наадамд хэлтсийн албан хаагчид хамгийн олон үндэстэн угсаатны хувцастай оролцон ДЭД байр, угсаатны хувцасны төрөлд Халх хувцас ДЭД байр, Цаатан хувцас Гутгаар байр эзлэн амжилттай оролцсон.






- УБЕГ-аас зохион байгуулж буй шинээр томилогдсон албан хаагчдын чиглүүлэх, дадлагжуулах сургалтад улсын бүртгэгч А.Ганчимэг хамрагдсан.






- Улсын бүртгэлийн байгууллагын 85 жил, Эрүүл Монгол хүн хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 09 сарын 20 ны өдөр “Алхалт-2025” байгууллагын албан хаагчид, гэр бүлийг оролцуулан Баян-Өндөр ууланд алхалт зохион байгуулсан.






- Албан хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэл зүйн боловсрол олгох ажлын хүрээнд “Амьдралоги” НҮТББ-тай хамтран 2025 оны 09 сарын 27 нд нийт албан хаагчдыг сэтгэл зүйн сургалтад хамруулсан.






- Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 85 жилийн ойг угтан Ерөнхий болосролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд “Миний хайртай Эрдэнэт” гар зургийн уралдаан зохион байгуулсан.






- Олон улсын”Ахмадын өдөр”-ийг тохиолдуулан 2025 оны 10 сарын 01 ний өдөр тэтгэвэрт гарсан ахмадуудаа хүлээн авч уулзан хүндэтгэл үзүүлж орон нутгийн 2 телевизээр






“Дурсамж яриа” нэвтрүүлэг хийлгэсэн.

- Хүний эрхийн үндэсний комиссоос Орхон аймагт зохион байгуулсан “Хүний эрх ба цахим технологи” сургалт, хэлэлцүүлэгт 4 албан хаагч хамрагдсан.




- Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийг угтан 2025 оны 10 сарын 10 өдөр Орхон аймгийн Засаг даргын Тамгын газарт өдөрлөг зохион байгуулсан. Тус өдөрлөгийн хүрээнд Орхон аймгийн бүртгэлийн байгууллагын түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн, бүртгэлийн үйлчилгээний талаархи мэдээлэл, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авсан**.**




## ГУРАВ. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2025 оны тайлангийн хугацаанд ахлах бүртгэгч -1, эрхийн улсын бүртгэгч – 5 хуулийн этгээдийн улсын бүртгэгч- 1, архивч -1 гэсэн бүрэлдэхүүнтэйгээр эд хөрөнгийн эрх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу явууллаа.

2025 оны 01 сарын 01-ний өдрөөс 2025 оны 11 сарын 07-ны өдрийн байдлаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт **56** төрлийн **17047 мэдүүлэг хүлээн авч 318 мэдүүлэг буцааж 16729** бүртгэл бүртгэсэн байна.

- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл- 11879
- Газрын бүртгэл-**5178**
- Бүртгэл хийхээс татгалзсан -318 мэдүүлэг татгалзсан байна.




➢ ***Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээг графикаар:***




➢ ***Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээг графикаар:***




**Өмнөх оны мөн үеийнхтэй эд хөрөнгийн бүртгэлийн үйлилгээг харьцуулбал:**




Онлайн бүртгэлээр Монголын ипотекийн корпорациас барьцааны гэрээ дуусгавар болгох-318 мэдүүлэг нотлох баримт ирүүлснийг хянаж, 38 бүртгэлийг татгалзаж, 280 бүртгэлийг холбогдох хууль журмын дагуу бүртгэж баталгаажуулсан.

Нотариатын зуучлалын үйлчилгээ-2 ирүүлснийг хүлээн авч шалган татгалзсан байна.

Монголын Ипотекийн Корпориацаас "Хөрөнгийн багцад тусгай тэмдэглэл бүртгүүлэх"-ээр ирүүлсэн 777 хувийн хэрэг бүртгэлд тусгай тэмдэглэлийг бүртгэсэн.

## ДӨРӨВ. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

- **Тоон гарын үсэг олголтын талаар**

Бүртгэлийн нэгж /улсын бүртгэгч нараар/-ээр дамжуулан Аймгийн хэмжээнд олговол зохих 73598 иргэнээс 40307 иргэнд тоон гарын үсэг буюу 54,7 хувьд нь олгосон бөгөөд тайлангийн хугацаанд 2025.01.02-ны өдрөөс 2025.11.07-ны өдрийг хүртэл хугацаанд 6460 тоон гарын үсэг олгосон байна. Тоон гарын үсэг олголтын мэдээг хүснэгтээр харуулвал.

| Огноо | Нийт | Иргэний үнэмлэх | Мобайл апп | Эрэгтэй | Эмэгтэй | 0 – 24 хүртэлх | 25 – 44 нас | 45 – 60 нас | 60 – с дээш |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2025 оны 1 сар | 864 | 151 | 713 | 414 | 450 | 88 | 346 | 291 | 139 |
| 2025 оны 2 сар | 1,159 | 126 | 1,033 | 529 | 630 | 90 | 413 | 434 | 222 |
| 2025 оны 3 сар | 503 | 32 | 471 | 268 | 235 | 36 | 252 | 160 | 55 |
| 2025 оны 4 сар | 523 | 47 | 476 | 244 | 279 | 46 | 219 | 190 | 68 |
| 2025 оны 5 сар | 591 | 53 | 538 | 276 | 315 | 39 | 232 | 242 | 78 |
| 2025 оны 6 сар | 579 | 47 | 532 | 307 | 272 | 43 | 249 | 198 | 89 |
| 2025 оны 7 сар | 487 | 25 | 462 | 259 | 228 | 33 | 239 | 144 | 71 |
| 2025 оны 8 сар | 614 | 24 | 590 | 309 | 305 | 60 | 256 | 212 | 86 |
| 2025 оны 9 сар | 577 | 14 | 563 | 316 | 261 | 32 | 234 | 213 | 98 |
| 2025 оны 10 сар | 473 | 14 | 459 | 248 | 225 | 40 | 210 | 158 | 65 |
| 2025 оны 11 сар | 90 | 0 | 90 | 37 | 53 | 6 | 33 | 34 | 17 |
| **НИЙТ** | **6,460** | **533** | **5,927** | **3,207** | **3,253** | **513** | **2,683** | **2,276** | **988** |

- **Иргэний үнэмлэх олголтын талаар**

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийг баримтлан иргэний гаргасан хүсэлтийн дагуу нийт 5159 иргэнд иргэний үнэмлэх олголоо. Нийт иргэний үнэмлэхний 1891 нь 16 нас хүрч анх удаа иргэний үнэмлэх авч буй иргэд байна. Мөн иргэний үнэмлэхний хугацаа дууссан иргэдийн 25 насны сунгалт 1046, 45 насны сунгалт 1183, хаяж үрэгдүүлсэн болон бусад шалтгаанаар 1039 иргэний үнэмлэх олгож ажиллалаа. Нийт 4120 бүртгэл, 8240 хуудас ИУБ-31 маягтын А талыг цахимжуулж цахим мэдээллийн санд баяжилтыг хийсэн байна.

Мөн иргэнийн үнэмлэхийн бүртгэл болон биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийг 2023, 2024 оны мөн үетэй харьцуулж үзэхэд:




- **Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн талаар**

Тайлангийн хугацаанд иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн чиглэлээр

- Төрсний бүртгэл 1538, цахимжуулсан хуудас 6152
- Гэрлэсний бүртгэл 302, цахимжуулсан хуудас 1510
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 173, цахимжуулсан хуудас 763
- Үрчилсний бүртгэл 38, цахимжуулсан хуудас 114
- Ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл 104, цахимжуулсан хуудас 468
- Эцэг, эх тогтоосны бүртгэл 45, цахимжуулсан хуудас 202
- Нас барсны 518 бүртгэл, цахимжуулсан хуудас 1554

нийт 2718 бүртгэл бүртгэж, 10763 хуудас эх нотлох баримтыг цахимжуулсан байна. Мөн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн ИУБ маягтын А талыг иргэний нэрийн эхний үсгээр эрэмбэлэн /цагаан толгойн дараалаар/ УБЕГ-ын Нэгдсэн архивын газарт зохих журмын дагуу ажлын 7 хоногийн дотор нь хүргүүлэн ажиллаа.

Мөн иргэнийн үнэмлэхийн бүртгэл болон биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийг 2023, 2024 оны мөн үетэй харьцуулж үзэхэд:

| | Төрөлт | Үрчлэлт | ОНӨ | Эцэг тогтоолт | Гэрлэлт | Гэрлэлт дуусгавар болсон | Нас баралт |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2023 он** | 1708 | 50 | 79 | 68 | 455 | 196 | 490 |
| **2024 он** | 1522 | 31 | 84 | 78 | 390 | 180 | 520 |
| **2025 он** | 1538 | 38 | 104 | 45 | 302 | 173 | 518 |

- **Гадаад паспорт олголтын**

Тайлангийн хугацаанд 7029 иргэнд гадаад паспорт олгосноос 5400 иргэнд цахим гадаад паспорт, 1629 иргэнд энгийн гадаад паспорт олгож.

Үйлчилгээний үнэ хураамжийн хувьд:

- Цахим паспортын 5400 – 418,5 сая төгрөг,
- Энгийн паспорт 1629 – 57,015 сая төгрөг

Улсын тэмдэгтийн хураамж 7029 – 35,145 сая төгрөг нийт 510,6 сая төгрөгний орлого төвлөрүүлж, 14058 хуудас материал цахимжуулсан байна.

Мөн гадаад паспортын бүртгэлийг 2023, 2024 оны мөн үетэй харьцуулж үзэхэд:

| | Цахим | Энгийн | Нийт бүртгэл | Төвлөрүүлсэн орлого |
|---|---|---|---|---|
| **2023 он** | 5354 | 3467 | 8821 | 580.380.000 төгрөг |
| **2024 он** | 8549 | 1000 | 9549 | 745.292.500 төгрөг |
| **2025 он** | 5400 | 1629 | 7029 | 510.600.000 төгрөг |

- **Иргэн шилжин суурьших хөдөлгөөний талаар**

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоолын дагуу 2025 оны бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэл 4473 иргэнд ИУБ-22 маягтыг хөтөлж 20128 хуудас материал цахимжуулсан байна. Мөн иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2023, 2024 оны мөн үетэй харьцуулж үзэхэд:

| | Насанд хүрсэн иргэн | 16 хүртэлх насны хүүхэд | Нийт шилжсэн иргэн |
|---|---|---|---|
| 2023 он | **4678** | **4230** | **8908** |
| 2024 он | **7215** | **5179** | **12394** |
| 2025 он | **4473** | **4194** | **8667** |

- **АНСДИТХ-ын нөхөн сонгуультай холбоотой хэрэгжүүлсэн ажил**

Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 28 ны өдрийн 26 дугаартай “Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн санал авах өдрийн товыг тогтоох тухай” тогтоолыг сонгуулийн системд бүртгэж, санал авах байрын баталгаажуулан ажиллаж байна.

АНСДИТХ-ын нөхөн сонгууль болохтой холбоотойгоор УБЕГ-ын даргын 2025 оны А/71 дүгээр тушаалын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Оюут 2-р багт иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжих шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн сонгуулийн санал хураах өдрийг дуустал хугацаагаар түр хугацаагаар зогсоосон.

АНСДИТХ-ын нөхөн сонгуулийн төлөвлөгөөний дагуу 2025.05.26-ны өдөр хэлтсийн даргын А/10 дугаартай тушаалаар итгэмжлэгдсэн ажилтанг томилсон.

2025.05.26-ны өдөр сонгогчийн нэрийн жагсаалтыг хэвлэж, АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.9 дэх хэсэгт “... цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллага орон нутаг дахь газар, хэлсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ.” гэж заасны дагуу 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр итгэмжлэгдсэн ажилтнуудыг байлцуулан хэсгийн хороонд хүргэж, холбогдох албан тушаалтанд илтгэх хуудсыг хүргүүллээ.

| Д/д | Сонгуулийн хэсгийн дугаар | Сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгогчдын тоо | Үндсэн сонгогч | “Түр хасав” нэмэлт тэмдэглэгээ тавигдсан сонгогч |
|---|---|---|---|---|
| 1 | **2** | **3** | **4** | **5** |
| 1 | 12-1-4 | 1241 | 1182 | 59 |
| 2 | 12-1-5 | 1572 | 1420 | 152 |
| 3 | 12-1-6 | 1891 | 1741 | 150 |
| нийт | | 4704 | 4343 | 361 |

АНСДИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль Орхон аймгийн Баян-Өндөр сумын Оюут 2-р багийн 12-1-4, 12-1-5, 12-1-6 хэсэгт Улаанбаатарын цагаар 07:00 цагт нээлтийн тайлан хэвлэснээр санал хураах ажиллагаа хэвийн явагдаж, АНСДИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийг Улаанбаатарын цагаар 20:00 цагт санал хураалтын ирц бүртгэлийн мэдээг серверт бүрэн илгээлээ. Сонгуулийн санал хураах өдөр тоног төхөөрөмж гацсан, сонгогч андуурч бүртгэлийн хуудас хэвлэсэн гэх ямар нэг алдаа зөрчилгүй ажиллаалаа. */сонгуулийн ирцийг хүснэгтээр харуулвал/*

**ТАВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**

| Д/д | Сум / Дүүрэг | Хэсэг | Үндсэн | санал өгсөн | хувь | Үүнээс | | | | хүйс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуруууны хээ | Рд | Зө | Сэр | эр | эм |
| 1 | Баян-Өндөр | 12-1-4 | 1185 | 218 | 18.4 | 214 | 0 | 1 | 3 | 106 | 112 |
| 2 | Баян-Өндөр | 12-1-5 | 1422 | 397 | 27.9 | 390 | 3 | 2 | 2 | 162 | 235 |
| 3 | Баян-Өндөр | 12-1-6 | 1743 | 395 | 22.7 | 382 | 7 | 4 | 2 | 164 | 231 |
| Нийт | | | 4350 | 1010 | 23.2 | 986 | 10 | 7 | 7 | 432 | 578 |

2025 оны 01 сарын 01-ний өдрөөс 2025 оны 11 сарын 07-ны өдрийн байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт **3648** үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс Цахимаар https://e-business.mn/home системээр **1776** хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажилт хийж ажиллалаа

| Д/д | Бүртгэлийн төрөл | | Бүртгэлийн тоо мэдээ | Нийт тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Шинээр байгуулагдсан хуулийн этгээд | Шинээр байгуулагдсан ХХК | 274 | **345** |
| 2 | | Төрийн бус байгууллага | 43 | |
| 3 | | Үйлдвэрчний эвлэлийн байгууллага | 2 | |
| 4 | | Хоршоо | 22 | |
| 5 | | Нөхөрлөл | - | |
| 6 | | Төрийн байгууллага, албан газар | 1 | |
| 7 | | Боловрол сургалтын газар | 3 | |
| 8 | Мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах | | 597 | **1527** |
| 9 | Хяналтын дугаар олголт | | 463 | |
| 10 | Хууль хяналтын байгууллагад олгосон лавлагаа | | 211 | |
| 11 | Тамга тэмдэг хураан авсан | | 72 | |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | Дахин гэрчилгээ авсан | 108 | |
| 13 | Татан буугдсан | 17 | |
| 14 | Шилжиж ирсэн | 27 | |
| 15 | Хориг тавьсан | 6 | |
| 16 | Хориг цуцалсан | 5 | |
| 17 | Салбар төлөөлөгчийн газрын бүртгэл | 11 | |
| 18 | Салбар төлөөлөгчийн газрын өөрчлөлт бүртгэгдсэн | 18 | |
| 19 | Өөрчлөн зохион байгуулсан | 1 | |
| 20 | Хэлбэр өөрчлөгдсөн | 11 | |
| 21 | Цахимаар https://e-business.mn/home системээр олгосон нэрийн баталгаажуулалт | **1776** | |
| **НИЙТ** | | **3648** | |




**ЗУРГАА. АРХИВИЙН ЧИГЛЭЛЭЭР**

2025 оны 11 сарын 07 ны өдрийн байдлаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт нийт 51859, иргэний улсын бүртгэлийн архивт 148005, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт 6400 гаруй хувийн хэргүүд хадгалагдаж байна.




## ДОЛОО. АЛБАН БИЧГИЙН ЭРГЭЛТ, ТУШААЛ, ШИЙДВЭР, ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТАЛААР

➢ **Албан бичгийн эргэлтийн талаар**

Тайлангийн хугацаанд тус хэлтэст нийт 1803 албан бичиг ирснээс 1628 хариутай бичиг албан бичиг ирсэн. Тухайн хариутай бичгийг цаг хугацаанд хариуг хүргүүлж ажилласан.

Ирсэн бичгүүдийг ангилан авч үзвэл.

- Цагдаагийн байгууллагаас 213 албан бичиг хүлээн авч албан бичгээр болон архивын лавлагаагаар хариу хүргүүлсэн.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 390 албан бичиг хүлээн авч албан бичгээр болон архивын лавлагаагаар хариу хүргүүлсэн.
- Шүүхийн байгууллагаас 755 албан бичиг хүлээн авч хариу хүргэсэн.
- УБЕГ-аас 155 албан бичиг ирснийг ангилан авч үзвэл тушаал 31, үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмж 25 тус тус ирсэн байна.
- Бусад байгууллагаас 290 албан бичиг хүлээн авч хариуг хүргүүлэн ажилласан байна.
- Нийт 1683 бичиг боловсруулан илгээж шүүх, шуудан, бусад байгууллагад хүлээлгэн өгч ажилласан.
- И-Оффисоор 325 бичиг хүлээн авч шийдвэрлэсэн. 32 бичиг илгээсэн.
- Erp.e-mongolia 415 албан ирсэн хүлээн авч шийдвэрлэсэн. 1298 явсан бичгийг боловсруулж хүргүүлсэн. Мөн албан бичиг солилцооны дундын систем болох /Docx/-р 575 бичиг илгээгдэж 126 бичиг хүлээн авч шийдвэрлэсэн.

**Өмнөх оны мөн үетэй харьцуулан харвал:**



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ирсэн бичиг 8,8 хувиар өссөн, явсан бичиг 45,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Тушаал шийдвэр, хурлын тэмдэглэлийн талаар**

Тайлангийн хугацаанд хэлтсийн даргын А тушаал 28, Б тушаал 15 гарч даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл 4, хэлтсийн шуурхайн тэмдэглэл 26 хөтлөгдсөн байна.

**Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн талаар**

Тайлангийн хугацаанд иргэдээс нийт 13 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаа. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг ангилан авч үзвэл:

<table>
<tr><th colspan="6">1. Өргөдөл, гомдлын ангилал</th></tr>
<tr><td>Өргөдөл</td><td>Хүсэлт</td><td>Гомдол</td><td colspan="2">Талархал</td><td>Санал</td></tr>
<tr><td>1</td><td>9</td><td>2</td><td colspan="2">1</td><td>-</td></tr>
<tr><th colspan="6">2. Өргөдөл, гомдол хүлээн авсан хэлбэр</th></tr>
<tr><td colspan="2">Бичгээр</td><td>Утсаар</td><td colspan="2">Цахим /70353511/</td><td>ЗГ 11-11</td></tr>
<tr><td colspan="2">5</td><td></td><td colspan="2">6</td><td>2</td></tr>
<tr><th colspan="6">3. Өргөдөл гомдлын агуулга</th></tr>
<tr><td colspan="2">Иргэний бүртгэлийн чиглэлээр</td><td>Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр</td><td colspan="2">Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр</td><td>Бусад</td></tr>
<tr><td colspan="2">6</td><td>2</td><td colspan="2">1</td><td>4</td></tr>
</table>

**2024 онтой харьцуулахад:**

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48 хувиар өргөдөл, гомдол, санал, хүсэлт буурсан байна.




## НАЙМ. ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЛААР

Тайлант хугацаанд /2025.11.07/ хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөний дагуу улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

- Иргэний улсын бүртгэлийн **-2112**
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн **-186**
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн **-446**

нийт **2744** бүртгэлд байнгын болон түүвэрчилсэн хяналт тавьж, сар бүрийн тоон мэдээг Хяналт, шалгалтын газарт хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгө эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зөрчилтэй холбоотой нийт 122 өргөдөл, гомдлыг хүлээн авсан. Үүнээс:

- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр -15

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 106
- Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 1 гомдлыг хуульд заасан журмын дагуу хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үйлдэн, зөрчлийг бүрэн арилган шийдвэрлэж,







улсын бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.

- 2025 оны 11 сарын 07 ны байдлаар Зөрчил шалган шийвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20-д заасан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 270 иргэн, 3 хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлыг хүлээн 6,965,000 төгрөгийн торгууль оногдуулж хуулийн хугацаанд нь прокурорт хянуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.
- Хэлтсийн иргэний улсын бүртгэлийн цахимжуулах ажил хэвийн явагдаж байгаа бөгөөд нийт 2112 бүртгэлийг цахим санд бүрэн цахимжсан эсэхэд хяналт тавьж ажилласан.
- Цахимжуулсан иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн мэдээлэл бүрэн, бичилтийн шаардлагыг хангасан, эх хувьтай таарч байх бөгөөд ХААТР маягтад бичигдсэн мэдээлэл бичилтийн шаардлага хангасан, нотлох баримтын бүрдлийн шаардлага хангасан алдаа, зөрчилгүй байна.
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн 446 бүртгэлийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичиг бүрэн гүйцэд цахимжсан эсэхийг түүвэрчлэн шалгахад зөрчилгүй байна.
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд алдаатай цахимжсан болон алдаатай бүртгэгдсэн 176 мэдээллийг архивын эх нотлох баримттай тулган засварласан.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн хүрээнд Монголын Ипотекийн корпорациас цахимаар ирүүлсэн барьцааны гэрээ дуусгавар болгох үйлчилгээг шалган 79 бүртгэлийн зөрчлийг арилгасан.
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн 186 бүртгэлийг мэдээллийн санд эх нотлох баримт бичиг бүрэн цахимжсан зөрчил илрээгүй болно.

- Хяналт шалгалтанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийг таниулах, энэ төрлийн зөрчлийг давтан гаргуулахгүй, урьдчилан сэргийлэх зорилгоор гарын авлага, санамжийг бэлтгэн 30 хуулийн этгээдэд тараан өгч, Улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж, Зөрчлийн тухай хуулийг сурталчлах арга хэмжээг авч ажилласан.

## ЕС. САНХҮҮ, АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

- **Батлагдсан төсвийн хүрээнд хэлтсийн мөнгөн хөрөнгө үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулсан.**

2025 оны 10 сарын 30-ны байдлаар тус хэлтэст Улсын бүртгэл, мэдээлэл хөтөлбөрийн 5 арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд дээрх арга хэмжээг санхүүжүүлэх үндсэн үйл ажиллагааны санхүүжилт 886,9 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн 176,2 сая төгрөг, нийт 1,063,2 сая төгрөгийн төсвийн зарцуулалтын эрх нээгдсэн.

Батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, зардлын бүлэг зүйлийн дагуу хугацаанд нь зарцуулан ажиллаж байна.

**Батлагдсан төсөв, зарцуулалт / арга хэмжээ тус бүрээр /төгрөгөөр/**

| № | Арга хэмжээний нэр | Батлагдсан төсөв | Зарцуулалт | Хэтрэлт /хэмнэлт/ |
|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 886,9 | 882,5 | 4,4 |
| 2 | Туслах үйл ажиллагааны зардал | 176,2 | 169,2 | 7,0 |
| 4 | АНСДИТХ-ын нөхөн сонгуулийн зардал | 4,132.5 | 4,132.5 | - |
| **Нийт дүн** | | **1,067,2** | **1,055,8** | **11,4** |

- **Үйлчилгээний орлого төвлөрүүлэлт**

Тус хэлтэс нь 2025 онд 195.0 сая.төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээс 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 371,1 сая төгрөгийг сар бүр хугацаанд нь төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөгөөний биелэлт 190 хувьтай байна.

- **Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирлын санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамт хуульд заасан хугацаанд ерөнхий газарт хүргүүлнэ.**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтэст дараах нэр төрлийн мэдээ, тайланг “Төсвийн тухай хууль”-д заасан хугацаанд нь сар, улирал бүр цахим шуудангаар болон шаардлагатай тохиолдолд эх хувиар нь хүргүүлэн ажиллаж байна.

Тайлант онд Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газраас орон даяар явагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого”-д хуулийн хугацаанд бүрэн хамрагдан Өмч эзэмшүүлэх гэрээг “**100% БУЮУ МАШ САЙН**” үнэлгээгээр дүгнүүлсэн болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасны дагуу 2025 оны 1, 2, 3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн.

2024 оны Санхүүгийн тайлангийн аудитын газраас 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн бөгөөд зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр гарган Орхон аймаг дахь Төрийн Аудитын газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газар тус тус хүргүүлсэн болно.

Байгууллагын 2025 оны өмч хөрөнгийн хагас жилийн тооллогыг тогтоосон хугацаанд хийж тайлан балансt тусгасан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Хөрөнгийн бүртгэлийн цахим системд 2025 оны 04 сарын 20-ны өдрийн дотор бүх хөрөнгийн зураг, үзүүлэлт, маркаар ангилан тайлагнан илгээж баталгаажуулсан.

2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар тус хэлтсийн хэмжээнд нийт 50925 ширхэг үнэт цаас үлдэгдэлтэй байсан бөгөөд 2025 оны 11 сарын 07 ны өдрийн байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газраас 35131 ширхэг үнэт цаас татан авалт хийснээс 66083 ширхэг үнэт цаасыг зарцуулан тус хэлтэст 44196 ширхэг үнэт цаас үлдэгдэлтэй байна.

Үнэт цаасны тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнан хүргүүлж байна.

## АРАВ. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

- ✓ Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2025 оны 11 сарын 07 ны байдлаар орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах гэрээний хүрээнд Орхон аймгийн Засаг даргын нөөц сангаас 4 гэрээт албан хаагчийн цалин болох 19,125 сая төгрөгийн санхүүжилт, Хөдөө орон нутгийн нэмэгдэл цалин 85,8 сая төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд бүртгэлийн үйлчилгээг хүртээмжтэй чирэгдэлгүй хүргэх зорилгоор 4G зөөврийн тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлэн зорилтот бүлгийн иргэдэд, ёс, албан байгууллагуудад хүрч үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.
- ✓ Бүртгэгч нарын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор аймгийн Тамгын газарт хүсэлт гаргаснаар эд хөрөнгийн ахлах бүртгэгч С.Жамбалсүрэн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтанд хамруулллаа.
- ✓ Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойн арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргад хүсэлт тавьж хэлтсийн байранд 76 сая төгрөгийн урсгал засвар хийх хөрөнгийг шийдвэрлүүлснээр иргэдэд үйлчлэх үйлчилгээний танхим, эд хөрөнгийн бүртгэлийн архив, ариун цэврийн өрөөний засвар тохижилтыг хийснээр албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирч иргэд тав тухтай үйлчлүүлэх боломжийг бий болгосон.






| Засварын өмнө нь | Засварын  дараа нь |
| --- | --- |
| Үйлчилгээний танхим | |
|  |  |
| Ариун цэврийн өрөө | |
|  |  |
| Эд хөрөнгийн архивын өрөө | |
|   |  |

✓ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээний хүрээнд  2025 оны 01 сарын 21-ний өдрөөс 2025 оны 01 сарын 26-ны өдрүүдэд хэлтсийн албан хаагчид болон тэдгээрийн гэр бүлийн нийт 51 хүнийг үзлэг оношилгоонд хамруулснаас,  1 албан хаагчийн ар гэрийн хүн элэгний хорт хавдраар оношлогдон яаралтай хагалгаанд орж эмчлүүлсэн бөгөөд зорилтот арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байна. Мөн энэ оны IV дүгээр улиралд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар хуваарь батлуулсан.

 

- ✓ 2025 оны 01 сарын 20-ны өдөр албан хаагчдыг багийн сэтгэлзүйн сургалтанд хамруулсан.



✓ Орхон аймгийн Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан төрийн албан хаагчдын дунд зохион байгуулагдсан буудлага, дартс, олс таталтын тэмцээн, мөсний баярын тэмцээнд албан хаагчид амжилттай оролцсон.




➢ “Хуульчийн Про Боно -2025” өдөрлөгт оролцож иргэд, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн талаарх үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл хүргэн, бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлан ажилласан. Иргэний бүртгэлийн чиглэлээр 115, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэл талаар 63 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн.




➢ Орхон аймгийн Баянбулаг багт зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгт иргэдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, зөвлөгөө мэдээлэл хүргэн ажилласан.




➢ Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ой, хамтын ажиллагаа, туршлага солилцох ажлын хүрээнд хэлтсийн 9 албан хаагч 2025 оны 06 сарын 06-ны өдөр Дархан, Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж, мэдлэг мэдээлэл, туршлагаа солилцох ажлыг зохион байгууллаа.

- Мөн 2025 оны 06 сарын 27 нд 10 албан хаагч Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаатай танилцан мэдлэг, мэдээлэл, туршлага солилцох ажлыг зохион байгуулсан.

ы




- Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан Монгол улсад орчин цагийн биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөний 101 жилийн ой, "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд "Төрийн албан хаагчдын цасны баяр-2025" арга хэмжээнд хэлтсийн албан хаагч нар амжилттай оролцсон.






- Хүний эрхийг хангах ажлын хүрээнд 2025 оны 01 сарын 23 нд Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар – 437 дугаар нээлттэй хорих ангитай хамтран ял эдэлж байгаа 8 иргэний, иргэний үнэмлэхний дахин захиалга, 2 иргэний 25 насны сунгалт, 1 иргэний гэрлэлтийн бүртгэлийг зөөврийн тоног төхөөрөмж ашиглан бүртгэж бичиг баримтжуулж иргэний үнэмлэхийг хүлээлгэн өгч ажиллалаа.
- Мөн УБЕГ-ын №1/285 удирдамжийн дагуу ШШГГ-ын харъяа 437 дугаар нээлттэй хорих ангид бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:

  Гэрлэсний бүртгэл 2 иргэн
  БДӨБ, иргэний үнэмлэхний сунгалт 10
  Иргэний үнэмлэх дахин захиалга 22
  Иргэний үнэмлэх, оршин суугаа хаягийн лавлагаа 3
  Хаяггүй иргэний хаягын бүртгэл 2
  Ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг 12 иргэнд олголоо.




- Монгол улсад ноториатын байгуулага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан 2025 оны 10 сарын 16 өдөр зохион байгуулсан "Ноториатын эрх зүйн хөгжлийн чиг хандлага" сэдвэт хэлэлцүүлэгт хэлтсийн дарга М.Отгонбаяр, улсын ахлах бүртгэгч С.Жамбалсүрэн, О.Үзмээ, улсын бүртгэгч О.Сарангэрэл, Ө.Ганзориг, Б.Батэрдэнэ нар оролцсон. Тус хэлэлцүүлэгт  С.Жамбалсүрэн "Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд нотариатын зуучлал, цахим бүртгэлийн системийг нэвтрүүлэх нь" сэдвээр илтгэл тавьсан.





- Орхон аймгийн Баян-Өндөр сумын багуудын Засаг дарга, зохион байгуулагч нарт 2025 оны 10 сарын 17нд “Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл”-ийн талаар мэдээлэл өгч холбогдох хууль тогтоомжийг тайлбарласан.






- Орхон аймгийн банк, банк бус санхүүгийн байгууллагуудтай 2025 оны 10 сарын 23 өдөр санал, хамтын ажиллагааны чиглэлээр уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтад АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн үйлчилгээний цахим хэлтэс, Орхон аймаг дахь Монгол банк, Голомт, Хаан, Худалдаа хөгжил, Ариг, Капитрон банкны салбарууд болон Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагын төлөөллүүд оролцсон. Арга хэмжээний үеэр Иргэний бүртгэлийн ахлах бүртгэгч О.Үзмээ "Тоон гарын үсэ, лавлагаа мэдээлэл", Эд хөрөнгийн ахлах бүртгэгч С.Жамбалсүрэн Эд хөрөнгийн эрхийн бүртгэл, түүнтэй холбоотой гэрээ хэлцэл бүртгүүлэх" сэдвээр тус тус илтгэл тавьсан.

- 2025 оны 10 сарын 24 нд Жаргалант суманд иргэдэд бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлж, өдөрлөг зохион байгуулсан.

 

## АРВАН НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛСАН ШИНЭЛЭГ АЖИЛ

| Д/д | Шинээр санаачилсан ажил | Зураг |
|---|---|---|
| 1 | Байгууллагын дэргэдэх Эцэг, эхийн зөвлөлөөс санаачлан албан хаагчдад зориулсан зөвлөмжүүдийг бэлтгэн хүргүүлэн ажиллалаа. |    |
| 2 | Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 85 жилийн ойг угтан “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын хүрээнд хэлтсийн албан хаагчдын дунд “Хичээнгүй, алдаагүй зөв бичиг” төрлөөр МОНГОЛ БИЧГИЙН уралдаан зарласан бөгөөд Тэргүүн байрт Иргэний улсын бүртгэлийн архивч Б.Энхтуул, Дэд байрт Иргэний улсын бүртгэгч Г.Саруул, Гутгаар байрт Мэдээлэл технологийн ажилтан Б.Лхамцэрэн нар тус тус шалгарч өргөмжлөл шагнал олголоо. |   |

| | | |
|---|---|---|
| **3** | Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ой, “Үндэсний бичиг III” хөтөлбөрийн хүрээнд үйлчилгээний стандартад нийцүүлэн иргэдэд үйлчлэх үйлчилгээний танхим, өрөө тасалгаа бүрийн хаягийг хос бичвэрээр бичиж шинэчиллээ. |   |
| **4** | Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85 жилийн ойг угтаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон хэлтсийн ойн арга хэмжээг тэмдэглэх төлөвлөгөөний дагуу “Хөдөлгөөн-Эрүүл мэнд “ аяны хүрээнд албан хаагчид 7 хоног бүрийн пүрэв гаригт мэргэжлийн бүжгийн багшаар удирдуулан бүжгээр хичээллэж байна. |   |
| **5** | Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85 жилийн ойг угтаж албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн санаачлагаар “Хөдөлгөөн-Эрүүл мэнд “ аян зохион байгуулж, тус аяны хүрээнд 7 хоног бүрийн 2 дахь өдөр спорт зааланд дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн. |  |
| **6** | Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85 жилийн ойг угтаж “Үндэсний бичиг III” хөтөлбөрийн хүрээнд нийт албан хаагчдын дунд Хөдөлмөрийн дотоод журам, ёс зүй болон монгол хэл бичгийн хэрэглээг дэмжих, мэдлэг чадварыг хөгжүүлэх, үндэсний бичиг соёлоо сурталчлах зорилгоор Алтан хонх тэмцээнийг зохион байгууллаа. |   |

| | | |
|---|---|---|
| 7 | Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 85 жилийн ойг угтсан үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулах Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн төлөвлөгөөний дагуу албан хаагчдад эерэг хандлага түгээхээр сар бүрийн сүүлийн 7 хоногийг “АЗ ЖАРГАЛТАЙ ӨДРҮҮД” байгууллагын соёлын арга хэмжээг 2025 оны 05 сарын 26-ны өдрөөс зохион байгуулж эхэллээ. |    |
| 8 | Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85 жилийн ойг угтаж хэлтсийн дэргэдэх Эцэг эхийн зөвлөлөөс Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийгмийн хариуцлагын хүрээнд 2025 оны 05 сарын 30-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих “Найдвар төв”-ийн болон зорилтот бүлгийн нийт 85 хүүхдийг баярлуулж гарын бэлэг өглөө. |     |
